

ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2023 оны ... дугаар
сарын-ны өдөр

Дугаар

Улаанбаатар хот

Тариф батлах тухай

Эрчим хүчний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4, 9.2 дахь хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 67 дугаар зүйлийн 67.2 дахь хэсгийг тус тус үндэслэн Эрчим хүчний зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Орхон аймгийн Баян-Өндөр сумын ахуйн хэрэглэгчдэд борлуулах дулааны тарифыг индексжүүлж, хавсралтаар баталсугай.

2. Батлагдсан тарифыг 2023 оны 09 дүгээр сарын 15-ны өдрөөс эхлэн мөрдөж ажиллахыг Орхон аймгийн Баян-Өндөр сумын төвлөрсөн дулаан хангамжийн хүрээнд дулаан түгээх, дулаанаар зохицуулалттай хангах үйл ажиллагаа эрхэлж буй тусгай зөвшөөрөл эзэмшигч компани, аж ахуйн нэгж, байгууллагуудын дарга, захирал нарт үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Ажлын алба (Б.Болор-Эрдэнэ)-нд даалгасугай.

4. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан Эрчим хүчний зохицуулах хорооны “Тариф батлах тухай” 2019 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн 121 дүгээр тогтоолын хавсралтын 2 дахь хэсэгт заасан ахуйн хэрэглэгчдэд борлуулах дулааны тарифыг хүчингүй болгосугай.

ГАРЫН ҮСЭГ

Баталгаажуулсан: Ажлын албаны дарга

Б.Болор-Эрдэнэ

Эрчим хүчний зохицуулах хорооны
2023 оны ... дугаар сарын ...-ны өдрийн
... дугаар тогтоолын хавсралт

ОРХОН АЙМГИЙН БАЯН-ӨНДӨР СУМЫН АХУЙН ХЭРЭГЛЭГЧДЭД БОРЛУУЛАХ ДУЛААНЫ ТАРИФ

Ахуйн хэрэглэгчдэд борлуулах дулааны тарифыг (НӨАТ-гүй) ангиллаас нь хамааруулан төлбөр тооцох үзүүлэлтийн нэгжид дараах байдлаар тооцно.

№	Хэрэглэгчдийн ангилал		Хэмжих нэгж	Тариф	
1	Орон сууцны халаалт (амьдрах зориулалт бүхий байр, подваль, "О"-ын өрөөний халаалт хамаарна)		Төг/м ²	648.00	
			Төг/ГЖ	7,184.00	
2	Хэрэгцээний ус халаасан дулаан	Хүний тоогоор	Халаалтын улиралд	Төг/хүн	3,366.00
			Халаалтын бус улиралд	Төг/хүн	5,051.00
		Усны зарцуулалтаар		Төг/м ³	3,200.00
		Хэмжүүрээр		Төг/ГЖ	7,184.00
3	Ахуйн хэрэглэгчдийн дулааны эрчим хүчний үйлчилгээний тариф				
3.1	40 м ² -аас ихгүй талбайтай айл өрх		Төг/сар	4,250.00	
3.2	40 м ² -аас их 80 м ² –аас ихгүй талбайтай айл өрх		Төг/сар	7,100.00	
3.3	80 м ² -аас их талбайтай айл өрх		Төг/сар	14,000.00	